



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/11

Чингис хот

Байгууллагын үйлчилгээний  
стандартын загвар батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 06 дугаар тогтоолын 4.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нутгийн захиргааны байгууллагын харьяа байгууллагуудын албан хаагчдын дагаж мөрдөх "Байгууллагын үйлчилгээний стандарт"-ын загварыг 1 дүгээр хавсралтаар, Байгууллагын үйлчилгээний стандарт нэвтрүүлэх байгууллагын нэрс болон хяналт тавих албан хаагчдын нэрсийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Холбогдох стандарт, аргачлалын дагуу боловсруулсан "Байгууллагын үйлчилгээний стандарт"-ын загварын дагуу байгууллага тус бүр өөрсдийн онцлогт нийцүүлэн дахин боловсруулж, албан хаагчдаараа хэлэлцүүлэн тушаалаар баталж, 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэст хүргүүлж, баталгаажуулан хэрэгжилтийг хангаж ажиллахыг агентлаг, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

"Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Стандарт, хэмжил зүйн хэлтэст хүргүүлэхийг агентлаг, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт, дүнг 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлэхийг Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга /Ч.Пүрэвдорж/-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Ж.Гантулга/-д тус, тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010042